

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/139/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Арвайхээр</p> <p>2022 он</p>	<p>Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал</p> <p>Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Гансүх</p> <p>Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com</p> <p>Аудитор: Б.Авидцэрэн</p> <p>Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Аудитын тайлан .....
- 3.1 Ерөнхий зүйл .....
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Материаллаг байдал .....
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....
- 3.8 Аудитын гол асуудал .....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
4. Аудитын илрүүлэлт .....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

## 1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АНГАМ ТАХЬ  
ТӨРНИЙ АУДИТЫН АГЛААР

БТГ-ийн дарга /Хүндэтгэсэн/ \_\_\_\_\_  
Төрийн аудитын байгууллагын дарга /Хүндэтгэсэн/ \_\_\_\_\_

2022.02.08 № 01  
САНГАЛ \_\_\_\_\_

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХТӨР ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33234215.00	19867553.00
33	АВЛАГА	13120000.00	
335	Бусад авлага	13120000.00	
3351	Байгууллагаас авах авлага	13120000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	20114215.00	19867553.00
354	Хангамжийн материал	20114215.00	19867553.00
3542	Аж ахуйн материал	2914655.00	2934655.00
3543	Сэлбэг хэрэгсэл	275000.00	475000.00
3547	Бусад хангамжийн материал	16924560.00	16457898.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2556372706.38	2531530084.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2556372706.38	2531530084.01
392	Биет хөрөнгө	2244403956.44	2219948834.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	2215081048.00	2215081048.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-126593740.68	-207508089.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103300000.00	51800000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-60269444.41	-17402777.69
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73185362.56	64832878.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56892362.42	-15070930.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79629045.00	48995682.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-73301951.61	-11044977.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	90266000.00	90266000.00
393	Биет бус хөрөнгө	311968749.94	311581249.90
39301	Програм хангамж	1550000.00	1550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-581250.06	-968750.10
39303	Бусад биет бус хөрөнгө	311000000.00	311000000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2589606921.38	2551397637.01
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1649807.13	11240.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1649807.13	11240.00
413	Өглөг	1649807.13	11240.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	1649807.13	
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		11240.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2587957114.25	2551386397.01
51	Засгийн газрын хувь оролцоо	2587957114.25	2551386397.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1985777424.00	1985777424.00
512	Хуримтлагдсан үр дүн	502330593.83	465759876.59
5121	Өмнөх үеийн үр дүн	502330593.83	502330593.83
5122	Тайлант үеийн үр дүн		-36570717.24
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99849096.42	99849096.42
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2589606921.38	2551397637.01

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	781958468.00	634863665.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133306918.00	56081815.52
120	Нийтлэг татварын бус орлого	133306918.00	56081815.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133306918.00	56081815.52
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10392700.00	2762500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	122914218.00	53319315.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648651550.00	578781850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		342270100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		342270100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42870850.00	24424250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25824000.00	14000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16320000.00	8774000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	726850.00	1650250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	605780700.00	212087500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	605780700.00	212087500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	743737306.92	671434382.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	743737306.92	671434382.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731267077.08	664258692.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283085504.13	277807419.00
210101	Үндсэн цалин	283085504.13	277807419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35521743.16	36155468.81
210201	Тэтгэврийн даатгал	24265922.60	25026379.93
210202	Тэтгэмжийн даатгал	2770661.64	2869971.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2295192.36	2138114.25
210204	Ажилгүйдлийн даатгал	561254.28	556454.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5628712.28	5564548.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196806700.00	204662548.00
210301	Гэрэл, цахилгаан	7622255.00	4264758.00
210302	Түлш, халаалт	187264000.00	196627200.00
210303	Цэвэр, бохир ус	1920445.00	3770590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17279451.00	6082619.00
210401	Бичиг хэрэг	1687000.00	683300.00
210402	Тээвэр, шатахуун	6499990.00	2182600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1800000.00	769917.00
210404	Ном, хэвлэл	203000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120000.00	789500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5151470.00	1657302.00
2105	Нормативт зардал	1000000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1000000.00	

**Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5790050.00	3770260.00
210604	Урсгал засвар	5790050.00	3770260.00
2107	Томилолт, зочны зардал	3033000.00	1004100.00
210702	Дотоод албан томилолт	3033000.00	1004100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6402840.00	3813540.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2343240.00	3813540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	372000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198600.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	
210807	Газрын төлбөр	3110000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182347788.79	130962737.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78800000.00	26920800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3600000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99947788.79	104041937.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12470229.84	7175690.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	3700000.00	1150000
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3700000.00	300000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		850000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8770229.84	4409152
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8770229.84	4409152
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		1616538.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		1616538.06
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38221161.08	-36570717.24
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38221161.08	-36570717.24

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,985,777,424.00	99,849,096.42	502,330,593.83	2,587,957,114.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,985,777,424.00	99,849,096.42	502,330,593.83	2,587,957,114.25
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
8	Тайлант үеийн үр дүн			-36,570,717.24	-36,570,717.24
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,985,777,424.00	99,849,096.42	465,759,876.59	2,551,386,397.01

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	659044250.00	594664350.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10392700.00	2762500.00
120	Нийтлэг татварын бус орлого	10392700.00	2762500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10392700.00	2762500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10392700.00	2762500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	648651550.00	591901850.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		342270100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		342270100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42870850.00	37544250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25824000.00	27120000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16320000.00	8774000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	726850.00	1650250.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	605780700.00	212087500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	605780700.00	212087500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	652020250.00	568784350.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	652020250.00	568784350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626430020.16	561608659.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281665697.00	279457226.13
210101	Үндсэн цалин	281665697.00	279457226.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35521743.16	36155468.81
210201	Тэтгэврийн даатгал	24265922.60	25026379.93
210202	Тэтгэмжийн даатгал	2770661.64	2869971.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2295192.36	2138114.25
210204	Ажилгүйдлийн даатгал	561254.28	556454.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5628712.28	5564548.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	196806700.00	204662548.00
210301	Гэрэл, цахилгаан	7622255.00	4264758.00
210302	Түлш, халаалт	187264000.00	196627200.00
210303	Цэвэр, бохир ус	1920445.00	3770590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13309990.00	5615157.00
210401	Бичиг хэрэг	1500000.00	683300.00
210402	Тээвэр, шатахуун	6499990.00	2182600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1800000.00	769917.00
210404	Ном, хэвлэл	390000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120000.00	699800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3000000.00	1279540.00
2105	Нормативт зардал	1000000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1000000.00	

**Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5690050.00	3991060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		240000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		200800.00
210604	Урсгал засвар	5690050.00	3550260.00
2107	Томилолт, зочны зардал	3033000.00	1004100.00
210702	Дотоод албан томилолт	3033000.00	1004100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6402840.00	3802300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2343240.00	3802300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	372000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	198600.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55000.00	
210807	Газрын төлбөр	3110000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83000000.00	26920800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	78800000.00	26920800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4200000.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12470229.84</b>	<b>7175690.06</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	3700000.00	1150000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3700000.00	300000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		850000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8770229.84	4409152.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8770229.84	4409152.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		1616538.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	13120000.00	1616538.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20144000.00	25880000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7024000.00	25880000.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	7024000.00	25880000.00
	Дотоод эх үүсвэрээр	7024000.00	25880000.00
221001	Их засвар	1200000.00	
222001	Тоног төхөөрөмж	5824000.00	25880000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7024000.00	-25880000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	564,627,000.00	551,094,409.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	564,627,000.00	551,094,409.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	563,777,000.00	550,244,409.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,461,700.00	279,457,226.13
210101	Үндсэн цалин	279,461,700.00	279,457,226.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,727,500.00	36,155,468.81
210201	Тэтгэврийн даатгал	26,548,900.00	25,026,379.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,794,600.00	2,869,971.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,235,700.00	2,138,114.25
210204	Ажилгүйдлийн даатгал	559,000.00	556,454.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,589,300.00	5,564,548.44
2103	Байр ашиглалттай холб. тогтмол зардал	209,071,200.00	204,662,548.00
210301	Гэрэл, цахилгаан	8,400,000.00	4,264,758.00
210302	Түлш, халаалт	196,627,200.00	196,627,200.00
210303	Цэвэр, бохир ус	4,044,000.00	3,770,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,568,300.00	4,568,267.00
210401	Бичиг хэрэг	500,000.00	628,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,167,500.00	2,182,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	595,000.00	241,917.00
210405	Хог хаягдал зайлуулах, ариутгал	605,300.00	699,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлс	700,500.00	815,650.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,220,500.00	3,216,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	204,200.00	200,800.00
210604	Урсгал засвар	3,016,300.00	3,015,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,004,500.00	1,004,100.00
210702	Дотоод албан томилолт	1,004,500.00	1,004,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,733,400.00	3,733,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,733,400.00	3,733,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,989,900.00	17,446,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,989,900.00	17,446,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	850,000.00	850,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	850,000.00	850,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	850,000.00	850,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	564,357,600.00	551,094,409.94
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	342,270,100.00	340,653,561.94
131001	Улсын төсвөөс санхүүжих	342,270,100.00	340,653,561.94
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	212,087,500.00	207,678,348.00
132001	Орон нутгийн төсвөөс	212,087,500.00	207,678,348.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	2,762,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	2,762,500.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
3	Төсвийн байгууллага	1	1
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
6	Удирдах ажилтан	1	1
7	Гүйцэтгэх ажилтан	14	14
8	Үйлчлэх ажилтан	4	4
9	Гэрээт ажилтан	4	4
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3	2
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	17
34	Гэрээт ажилтан	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		37,544,250.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		11,664,250.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		11,364,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,046,890.00
210401	Бичиг хэрэг		55,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		528,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		463,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		774,460.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		68,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		68,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		9,474,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		9,474,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		300,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,880,000.00
	Дотоод эх үүсвэрээр		25,880,000.00
222001	Тоног төхөөрөмж		25,880,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		37,544,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		37,544,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		27,120,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,774,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,650,250.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Биеийн тамир, спортын газар нь “Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх” эрхэм зорилготой, “Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох, спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан, өсвөрийн шигшээ багийн залгамж халааг бэлтгэх, тамирчдын спортын амжилтыг тив, дэлхий, олон улсын түвшинд хүргэх, биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллага нь Засгийн газрын тохируулагч агентлаг - Биеийн тамир, спортын улсын хороонд шууд харъяалагдах болсон ба байгууллагын бусад үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Газрын даргын 2018 оны а/14 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналт, шалгалтын баг ажилладаг ба Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан журам, байгууллагын даргын баталсан журмыг мөрдөж, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 747.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувь буюу 5.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 90.5 сая төгрөгөөр буурсан байгаа нь хөрөнгө акталсан, ашиглах хугацаа дууссан хөрөнгөд дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт ороогүй, 0.2 сая төгрөгөөр буурчээ.
- Өглөгийн дансанд оны эхэнд байсан үлдэгдэл болох ХХОАТ-ын өглөгийг барагдуулснаар нийт өглөг 1.6 саяар буурсан байна.
- Урьд онд авлагын дансанд үлдэгдлээр тайлагнасан 13.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 724.9 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 564.6 сая төгрөгөөр батлагджээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайланд оны төсөв 564.6 сая төгрөгөөр батлагдаж, тодотголоор хянагдсанаар 557.1 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 6.0 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 551.1 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газрын нэмэлт санхүүжилт тайлант онд 37.5 сая төгрөг, тухайлбал:

- оны эхний авлага 13.2 сая,
- Засаг даргын нөөцөөс зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт 14.0 сая,
- дээд байгууллага болох БТСУХ-ноос урладаан тэмцээний зардалд 8.8 сая,
- байгууллагын өөрийн орлого 1.7 сая төгрөг тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Төсөвт буцаан төвлөрүүлсэн санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байсныг залрууллаа. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэхэд алдаа зөрчил илрээгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 141 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

2022 онд тухайн байгууллагаас үйлчилгээний хэсэг нь биеэ даасан хуулийн этгээд болж салж байгаа тул хөрөнгө хуваарилж хоёр байгууллагын бүртгэлд тусгасан байдалд анхаарал хандуулах шаардлагатай.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн алдаа илэрсэн.

#### 4.1 Залруулсан алдаа

Төсөвт буцаан төвлөрүүлсэн санхүүжилтийн үлдэгдэл 6.0 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байсныг залрууллаа.

#### 4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

#### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй.

#### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Биеийн тамир, спортын газар	1	6.0	1	6.0						

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН

